



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн
2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудит



www.audit.mn

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

БҮХ НИЙТИЙН ҮЙЧИЛГЭЭНИЙ
ҮҮРГИЙН САНГИЙН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР Б.ЧИНБАТ ТАНАА

2017.03.24 № 3/529

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын эцсийн үлдэгдэл 1,033.8 сая төгрөгт хүрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

YAG-ын САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261628
Цахим хаяг:
boldch@audit.gov.mn
Аудитор: П.Цэнгүүн
Утас: 261885
Цахим хаяг:
tsenguunp@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар

САГ-2017/2/СТА-ЗГТС

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/2/СТА-ЗГТС/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 3 дугаар сарын 9-нөөс 2017 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ОНАА-ы аудитор П.Цэнгүүн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 7-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 3 дугаар сарын 9-нөөс 2017 оны 3 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд “Харилцаа холбооны тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай”, “Радио долгионы тухай”, “Шуудангийн тухай”, “Цахим гарын үсгийн тухай” зэрэг хуулиуд, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагааны хүрээнд Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолын хүрээнд Ерөнхий Сайдын 2016 онд баталсан БНҮҮС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд “Төрийн бодлогын хүрээнд мэдээлэл, шуудан, харилцаа холбооны хамгийн түгээмэл үйлчилгээг тухайн хүн амын байршил, амьжиргааны түвшингөөс үл хамааран бодит үнээр хүргэх, алслагдсан орон нутагт зайлшгүй шаардлагатай мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлэх, сүлжээг шинээр барьж байгуулах, өргөтгөх, үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ерөнхий менежер Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 19-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллага нь өөрийн баримталдаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй бөгөөд ХХМТГ-ын нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигласаар ирсэн байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Материаллаг байдал:

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт хөрөнгийн 1 хувиар тооцон 154.8 сая төгрөгөөр тогтоов.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан 2016 онд 3,100.0 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд гүйцэтгэлээр 2,058.9 сая төгрөгийн хөрөнгийг улсад төвлөрүүлж 1,041.1 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Тайлант жилд 2,342.2 сая төгрөгийн урсгал төсвийг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 2,309.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 32.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Үүний 2,159.4 сая төгрөгийн татаас шилжүүлгээр хийгдэх ажил үйлчилгээ нь хийгдэж санхүүжилтийг бүрэн авсан байна. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардал 150.5 сая төгрөг, урсгал, татаас шилжүүлэг 2,159.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Тус газар нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу өөрийн байгууллагын цахим хуудсанд шилэн данс цэсийг үүсгэн, www.shilendans.gov.mn сайттай холбож, уг цэсэнд байгууллагын 2016 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээллийг байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтуудыг санхүүгийн СТАУС програмд татаж хавсаргав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бичиг хэрэг, дотоод томилолт, урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн дадлага, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1.Тус сан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 496 байгууллагаас улсын төсөвт 3,100.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,058.9 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1,041.1 сая төгрөгөөр буюу 33.6 хувиар тасалдуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Улсын төсвийн орлого тасалдсан дээр дурдсан шалтгааныг үндэслэн уг асуудлыг холбогдох эрх зүйн актанд өөрчлөлт оруулах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 707.8 сая төгрөгөөр тасалсанд зөвлөмж өгөх.

2. БНҮҮС-ийн авлагын эхний үлдэгдэл 859.0 сая төгрөг байсан ба тайлант онд 295.3 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 470.1 сая төгрөгийн авлага шинээр нэмэгдэж авлага 1,033.8 сая төгрөгт хүрсэн байна. Энэхүү авлагын 14.8 хувь буюу 152.9 сая төгрөгийн авлага найдваргүй болох эрсдэл үүсээд байна. Энэ нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл нь цуцлагдсаны улмаас энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулахаа болисон нийт 48 байгууллагаас авах авлага байна.

Шийдвэрлэсэн: Хуримтлагдсан авлагыг шуурхай барагдуулах үүний дотор эрсдэл үүсэх магадлалтай авлагыг зохих шатны байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөх.

3. Дуусаагүй үйлдвэрлэл дансны эхний үлдэгдэл 11,579.1 сая төгрөг байсан ба тайлант онд 2,176.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 529.8 сая төгрөгөөр хасагдаж эцсийн үлдэгдэл 13,226.2 сая төгрөг болсон байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон ажил үйлчилгээ одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байсаар байна.

Шийдвэрлэсэн: Дуусаагүй үйлдвэрлэл дансанд удаан хуримтлагдсан үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хуулийн ажилтны хуульчдын холбооны гишүүний татварт 180.0 мянган төгрөгийн төлбөрийг гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т заасныг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөх.

2. Урсгал засварын зардлаас 1.2 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад санхүүжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрсөн байна.

Шийдвэрлэсэн: Баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийхгүй байх талаар зөвлөмж өгөх.

3. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч үндсэн хөрөнгийг түүвэрлэн хяналтын тооллого хийхэд 1.6 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг зөөврийн компьютер дутагдсан, компьютер, тоног төхөөрөмжүүдийн нэр, марк, хүчин чадал зөрүүтэй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийн тооллогыг дахин хийж нэр, марк, хүчин чадлын зөрүү гарсан шалтгааныг тогтоож, энэхүү зөрүүг арилгах, дутагдсан зөөврийн компьютерийг холбогдох ажилтнаар төлүүлэх талаар зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.2

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15,304.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1,033.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 14,270.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн бөгөөд албан шаардлагын биелэлт 30 хувьтай, зөвлөмжийн биелэлт 30 хувьтай байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Орлого.....2

Асуудал 2
Дуусаагүй үйлдвэрлэл.....3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Зардал.....4

Асуудал 2
Үндсэн хөрөнгө.....5

2017 оны 3 дугаар сар